



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг тус тус үндэслэн “Завхан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 484.7 (дөрвөн зуун наян дөрвөн сая долоон зуун мянга) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Завхан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын биелэлтээр 63.0 хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” байх тул санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Баттулга)-д үүрэг болгосугай.

3. “Завхан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай.

3.1. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах.

3.2. Компанийн батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

4. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Баттулга)-д үүрэг болгосугай.

4.1. “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй, хэмнэлттэй, үр ашигтай ажиллах;

4.2. Компанийн мөнгөн хөрөнгийн гүйлгээг хувь хүний дансаар дамжуулан зарцуулахыг таслан зогсоож, касс болон харилцах дансанд тавих хяналтыг сайжруулж ажиллах

4.3. Иргэн Б.Санжсүрэнгээс компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байх хугацаандаа албан тушаалын байдлаа ашиглан үүсгэсэн 175.2 сая төгрөгийн

авлагыг шүүхийн журмаар нэхэмжлэн авч компанийг хохиролгүй болгох арга хэмжээг зохион байгуулж ажиллах.

4.4.Иргэн М.Болдоос компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байх хугацаандаа компанийн хөрөнгөөс эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүй өөрийн эмчилгээний зардалд дур мэдэн зарцуулсан 1.0 сая төгрөгийг буцаан төвлүүлэх.

4.5.Иргэн Ц.Ариунжаргалаас компанийн ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байх хугацаандаа 67,1 сая төгрөгийг компанийн мөнгөн хөрөнгөөс бэлнээр авч захиран зарцуулсныг хууль хяналтын байгууллагаар шалгуулж санхүүгийн шатны баримтыг бүрдүүлэх.

4.6.Компанийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3 ширхэг, 37.5 сая төгрөгийн балансын үнэтэй ашиглалтгүй байгаа шуурхай хэсгийн ажлын байрны ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх

4.7.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах

4.8.Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд, өссөн дүнгээр 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн
02 дугаар тогтоолын хавсралт



“Завхан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга		Мөнгөн дүн (сая төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийж мөнгөн хөрөнгийг зарцуулсан	Зөвшөөрөлгүй байр тохижуулсан	32.9	Нягтлан бодох бүртгэлийн хууль болон мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах, Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах,
		Анхан шатны баримтын бүрдэлгүй	260.4	
		Түрээсийн төлбөрийн тооцоо нийлсэн актгүй	152.9	
		Эмчилгээний төлбөр	1.0	
2	Ашиглалтгүй байгаа үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт тавих хяналтыг сайжруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй	3 барилга	37.5	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг мөрдөж ажиллах
3	Газар эзэмших ашиглах эрхийг баталгаажуулсан боловч Засгийн газрын 2010 оны 10 дугаар тогтоолын дагуу үнэлж санхүүгийн тайланд тусгаагүй	Завхан аймгийн Улиастай хотод байрлах шуурхай хэсгийн газар	0	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг мөрдөж ажиллах
Нийт дүн			484.7 (дөрвөн зуун наян дөрвөн сая долоон зуун мянга)	